

БӨХМӨРӨН СУМЫН БЭЛЧЭЭР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго: Сумын газар нутаг, бэлчээрийг Газрын тухай хууль, холбогдох дүрэм, журмын дагуу ашиглаж бусад сумуудтай хил залгаа нутгийг бүрэн эзэмшиж ашиглах, хадлангийн талбай, өвөлжөөний бүс нутаг болон нөөцөлсөн бэлчээр нутгийг бүрэн хамгаалж, эзэмших, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангахад журмын зорилго оршино.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална:

2.1.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх, сэлгэж өнжөөх, амраах арга хэмжээг малчдын оролцоотойгоор төлөвлөн хэрэгжүүлэх.

2.1.2.Бэлчээрийн экологийн чадавх, бүтээмжит чанар, даацад нь суурилах;

2.1.3.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид “бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх) нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ(цаашид “фотомониторинг” гэх)-ний дүнд үндэслэсэн байх;

2.2.2.Бэлчээрийг улирлын хуваарьтайгаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг гаргасан байх;

2.2.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн байх;

2.2.4.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх.

Гурав. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1.Сумын хэмжээнд хэрэгжүүлэх “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг баталж мөрдүүлэх

3.1.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг баталж, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх.

3.1.3.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын хүрээнд үлгэр жишээ ашиглаж буй иргэн, малчдын хэсэгт давуу эрхээр улсын төсөв болон орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх, төрийн дээд одон медальд тодорхойлох.

3.2.Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1.Багийн бэлчээрт фото мониторинг хийж болох цэгийг тогтоох;

3.2.2.Жил бүрийн 5 дугаар сарын 01-ний дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

3.3.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.Газрын тухай хуулийн 52.2 дахь хэсэгт заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох;

3.3.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

3.3.3.Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийн үр дүнд үндэслэх;

3.3.4.Бэлчээр ашиглалтын гэрээний үүргээ биелүүлж ажиллаж байгаа баг, малчин өрхөд давуу эрхтэйгээр хөрөнгө санхүү, бодлогын дэмжлэг үзүүлэх;

3.3.5.Гол, горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалахаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахыг зогсоох арга хэмжээ авах;

3.3.6.Гаднаас ирсэн малчидтай “Бэлчээр ашиглуулах гэрээ” байгуулна

3.3.7. газрын тухай хуулийн 52.2 заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг чөлөөлөх, мал оруулах хугацаа болон отроор ирсэн малчдыг 3 сараас хэтрэхгүй байлгах

3.4.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

3.4.2.Тухайн жилд Бэлчээрийн санд төвлөрсөн хөрөнгөөр багийн иргэдийн Нийтийн Хурлаас шийдвэрлэсэн ажлыг хэрэгжүүлэх, тайлагнах.

3.5.ТХГН-ын хамгаалатын захиргаа нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ

3.5.1.Увс аймаг, Баян-өлгий аймаг болон ТХГН-ын нутгийн сумдын Засаг дарга нартай хамтран ажиллах.

3.5.2. Хамгаалалтын бүс нутгийн зэрлэг ан амьтны амьдрах орчин нөхцөлд бэлчээрийн мал аж ахуйн нөлөөллийг бууруулах.

3.5.3. Усны шувуу болон зэрлэг амьтдын амьдардаг зэгс, мод бут сөөгийг малын хөлийн талхагдлаас хамгаалах.

3.5.4.Тусгай хамгаалалттай газар нутагт байнгын эргүүл хяналт шалгалт хийх, зөрчил үйлдэхэд хэрэглэсэн эд хөрөнгийг хурааж авах, тухайн бүс нутгаас гаргах.

3.5.5. мал бэлчээрлүүлэх бүсийг тогтоож өгөх

3.5.6. хамгаалалтын бүс нутагт гарч болзошгүй гал түймэрийн аюулаас урьдчилан сэргийлэх.

3.5.7. хамгаалалтын бүс нутгийн даацыг тооцож, бэлчээрийн даацад тааруулж мал бэлчээрлүүлэх.

3.5.8. хамгаалалтын бүс нутгийн онцгой бүсэд мал бэлчээрлүүлэхгүй байх.

3.5.9. Малчид малаа байнгын хариулгатай байлгах.

Дөрөв.Бэлчээрийг ашиглуулах

4.1 Сумын иргэд нь багийн засаг даргад хүсэлт гарган багийн иргэдийн нийтийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшөөрсөн бүс нутагт өвөлжөөний хашаа барьж бэлчээр нутгийг эзэмшинэ.

4.2 Нөөцөлсөн бэлчээр, хадлангийн талбай өвөлжөө, намаржааны бүс нутагт мал оруулан гишгүүлэх, чөлөөлсөн хугацаанаас түрүүлж идүүлэх зөвшөөрөлгүйгээр тус бүс нутагт нүүдэллэхгүй байх

4.3 Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх болон бусад арга хэмжээнд мал эмнэлгийн ариун цэврийн дүрмийг мөрдөн дагаж биелүүлнэ.

4.4.Бэлчээрийг зөв зохистой ашиглах талаар гаргасан бүдүүвч зураглал, цаг хугацаа, бэлчээрийн хуваарь зэргийг багийн Иргэдийн Нийтийн Хурлын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж нэг хувийг Засаг даргын Тамгын газарт ирүүлэх бөгөөд энэ шийдвэр нь бэлчээр ашиглах журмын хавсралт болно.

4.5.Сумын иргэдэд уламжлалт бэлчээр ашиглаж байсан туршлагыг түгээн дэлгэрүүлэх

4.6.Нутаглаж байгаа газрынхаа гол ус, байгаль орчныг бохирдуулахгүй байх бүхий л үйл ажиллагааг иргэн бүр өөрийн санаачлагаар хийдэг байх,

4.7.Сумын нутаг дэвсгэрт байрладаг өвөлжөөний газрыг эзэмшигч нь гадны сумын иргэнд эрхээ шилжүүлэхгүй бөгөөд газар эзэмших эрхээсээ татгалзаж байгаа тухайгаа Засаг даргын тамгын газарт мэдэгдэж гэрээг дуусгавар болгож тооцоо хийсэн байна.

4.8.Энэ журмын 3.3.6-т заасан гадны малчин өрхөд бэлчээр ашиглуулсны төлбөрийн хэмжээ хонин толгой тутамд хоногт 20 төгрөг байна.Тэмээ үхэрт 6, адуунд 8, ямаанд 2 хонь тус тус оногдохоор тооцож шилжүүлнэ.

4.9.Өвөлжөө хаваржаандаа гадны мал бүхий өрх буулгасан, буусан иргэнд 4.8-т заасан хэмжээг 5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх төлбөр ноогдуулна.

4.10. Гадны малыг маллагч малчин эзнийх нь нэр дээр гадны аймаг, суманд мал бүртгүүлсэн бол энэ журмын 4.8-д заасан бэлчээр ашигласны төлбөр төлнө.

4.11. Сумын бэлчээрийн нөөц газар отороор ирж буусан малчин өрхөд бэлчээр ашиглуулсны төлбөрийн хэмжээ хонинд толгой тутамд хоногт 20 төгрөг байна. Оторлох хугацаа 90 хонгоос хэтрэхгүй байх.

Тав. Бэлчээрийн сан

5.1 Бэлчээрийн сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

5.1.1.Энэ журмын 3.3.6, 4.8, 4.9, 4.10, 4.11-д заасан бэлчээр ашиглуулсан төлбөр

5.1.2. Хандив, тусламж бусад эх үүсвэр

5.2 Бэлчээрийн сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна.

5.2.1. доройтсон бэлчээрийг нөхөн сэргээхэд чиглэлсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх

5.2.2. шаардлагатай бэлчээрт уст цэг гаргах

5.2.3.Бэлчээрийн хортон мэргэчидтэй тэмцэхэд

5.2.4. үүлэнд зориудаар нөлөөлөх зорилгоор генератор суурилуулах түүнтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд

5.2.5. өвс тэжээлийн нөөцийн сан бүрдүүлж, татвараа хуулийн хугацаанд нь төлдөг малчдад өвс, тэжээл хөнгөлттэй үнээр өгөх

5.2.6. Бэлчээр ашиглалтын журмыг үлгэр жишээ мөрдөж буй малчдыг шагнаж урамшуулах

Зургаа. Бэлчээрийг зохистой эзэмших ашиглах талаар:

Бэлчээр нутгийг ашиглаж ирсэн уламжлал, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагыг үндэслэн хаваржаа, өвөлжөө, зуслан, намаржаа, нөөц бэлчээр нутгийг доорхи байдлаар тогтоов.

5.1. Зуслангийн бүс нутаг:

5.1.1.Гурванжигэртэй баг: Цалгар, Банзар, Хавчуу, Урт булаг, Мушгуу, Нуурын хад,

5.1.2 Хар алтат баг: Баадай, Гэгээний салаа, Олон нуур, Улаан эрэг, Цагаан булан, Хужирт, Хэц, Таван худаг, Шаварт, Улаанбулаг, Гашгууртай, Ямаат, Улаансай, Хөндий дуут, Минжүүр, Суваг

5.2. Хаваржааны бүс нутаг.

5.2.1.Гурванжигэртэй баг: Жигэртэйн голоос Хэвийн эхэн хүртэл Цэхээ, Жигэртэй, Хэвийн эхэн, Авдар улиас, Модон овоо, Эргэнэг, Жидийн хоол, Морьтын толгой, Ганц улиас, Сэвшиг, Хөх үзүүр, Баруун хөвөө

5.2.2.Хар алтат баг: Уушиг, Хүв, Таван хар, Улиасан, Хуримтай, Давхар зах, Хадаан ус, Цөөхөн хус, Шинэ усан,

5.3 Намаржааны бүс нутаг:

5.3.1.Гурванжигэртэй баг: Бөхмөрөний гол, Цагаан түнгэ, Шар харгай, Тариг, Хэв

5.3.2.Хар алтат баг: Ачит, Зах, Хоз, Хадаан ус, Хусны эхэн

5.4 Өвөлжөөний бүс нутаг:

5.4.1.Гурванжигэртэй баг: Хойд хүрэм, Урьд хүрэм, Зүүн шил, Хоо морьт, Гүүн сай

5.4.2.Хар алтат баг: Уушиг, Улаан сай, Наран, Гашгууртай, Суваг, Ачит, Хоз

Зургаа . Журмыг мөрдөх хугацааны талаар:

6.1.Өвөлжөөний бүс нутагт нутаглах хугацаа: 12 дугаар сарын 15-наас 2 дугаар сарын 10 хүртэл

6.2.Зуслангийн бүс нутагт нутаглах хугацаа: 6 дугаар сарын 15-наас 8 дүгээр сарын 15 хүртэл

6.3.Хаваржааны бүс нутагт нутаглах хугацаа: 3 дүгээр сарын 15-наас 5-р сарын 15-нийг хүртэл

6.4.Намаржааны бүс нутагт нутаглах хугацаа: 9 дүгээр сарын 15-нээс 11 дугаар сарын 10 хүртэл, зарим бүс нутагт нутаглах хугацаа 2 үе шаттай байна.Тухайн асуудлыг багийн Иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж тогтооно.

Долоо. Журмын биелэлтийг хангах талаар:

7.1.Энэ журмыг биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг сумын Засаг даргын шийдвэрээр зохион байгуулана.

7.2.Журмын 5 дугаар зүйлийг дагаж мөрдөх

7.3.Журам зөрчсөн этгээд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.4.Журмын биелэлтийн явцыг жил бүр ИТХ-аар оруулж танилцуулж ажиллах.

Найм.Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх

8.1.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.10 дахь хэсэгт заасны дагуу багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж зохицуулна. Эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга шийдвэрлэнэ.

8.2.Бэлчээрт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар зохицуулна.

Ес.Журам хүчин төгөлдөр болох9.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актыг улсын бүртгэлд бүртгэж, Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГТ ХАДЛАН АШИГЛАХ, ХАМГААЛАХ ЖУРАМ

НЭГ: ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Журмын зорилго

Тусгай хамгаалалттай газар нутагт иргэд, аж ахуй нэгж хадлан бэлчээрийг зөв зохистой ашиглах, эзэмших, хамгаалах, өнжөөх, сэргээхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулж, зөрчил дутагдлыг арилгах, учирсан хохирлыг барагдуулах, энэ үйл ажиллагаанд иргэдийн тэгш оролцоог хангахад журмын зорилго оршино.

1.2. Журмыг дагаж мөрдөх

Монгол Улсын Үндсэн хууль, Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Газрын тухай хууль, Байгалийн ургамалийн тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, хадлангийн талбайг зүй зохистой ашиглаж хамгаалахад энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Журмыг хэрэгжүүлэх

Журмын хэрэгжилтийг сумдын Засаг даргын тамгын газар, Ачит нуур Дэвэлийн арал байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, сумдын Цагдаагийн тасаг /хэсэг/, Багийн засаг дарга нар, Орчны бүсийн малчид, ард иргэд

ХОЁР: ХАДЛАН АШИГЛАЛТЫН ЖУРАМ, ХУВААРЬ

2.1. Хадлан хадах гэрээний хугацааг зохих хуулийн заалтад нийцүүлэн тогтооно. Мөн жил бүр байгаль цаг уурын онцлог ургамалийн гарцаас шалтгаалан хугацааг өөр өөр тогтоож болно.

2.2. Байгалийн цогцолборт газарт хадлангийн талбайг 8 дугаар сарын 15-наас, 9 дүгээр сарын 25-ны хооронд намрын хадланг хадна.

2.3. Өвлийн хадланга 02 дугаар сарын 25-ны хүртэл хадна.

2.4. Энэхүү хугацаа зөвхөн БЦГ -ын хязгаарлалтын бүсд хамаарна.

ГУРАВ: ХАДЛАНГИЙН ТАЛБАЙГ ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ, ХАМГААЛАХ

3.1. Хадлангийн талбайг Ачит нуур Дэвэлийн арал БЦГХ Захиргаа нь иргэн, аж ахуй нэгжид хадлан хадах хугацаа, төлбөрийн хэмжээ, хадах газрын хэмжээ зэргийг тогтоож гэрээгээр ашиглуулна.

ДӨРӨВ: ХАРИУЦЛАГА

Журмыг зөрчигчдөд Монгол Улсын Эрүүгийн тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авна. Үүнд:

4.1. Журмын аливаа заалтыг зөрчсөн бол хуулийн 7.7 – ийн 1.2 хэсэгийн дагуу элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хууль бусаар бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун

тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.2. Хадлан хадах гэрээг бусдад дур мэдэн шилжүүлсэн, бусдад дур мэдэн ашиглуулсан бол Зөрчлийн тухай хуулийн 8.1-ийн 7-р заалтын хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.3. Энэ журмыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг эсэргүүцсэн буюу биелүүлээгүй иргэн хуулийн этгээдийг зохих хууль журмын дагуу хариуцлага хүлээлгэх бөгөөд биелэлтийг хангуулах үүднээс албадан нүүлгэх түүнтэй холбогдон гарах бүх зардлыг тухайн эзнээс гаргуулна

4.4. Ачит нуур Дэвэлийн арал БЦГ хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулахгүйгээр дур мэдэн хадлан хадсан, хадланг дур мэдэн ашигласан бол хуулийн дагуу торгож, бусдын хадланд учруулсан хохирлын хэмжээг тооцон нөхөн төлбөр оногдуулна.

4.5. Гэрээний заалтыг давтан зөрчиж, хадлангийн талбайг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах болон хог хаягдлын тухай нийтлэг шаардлагыг биелүүлээгүй бол гэрээг цуцална.

4.6. Хадлангийн гэрээ хийсэн өрх/иргэн/ өөрөө хадлангаа хадна.

4.7. Гэрээ байгуулсан хүн өөр хүнээр хадуулж болохгүй. /Гэрээгээ бусдад шилжүүлж болохгүй/

4.8. Хадланг Тэвх хусан, Өлхний харзаас доош хадна.

4.9. Туслах ажилтан өөрийн техниктэй ирэхгүй. Зөвхөн гэрээ байгуулсан талбай дээр туслах ажилтанаар ажиллана.

4.10. Гэрээ байгуулсан талбай дээр өөр иргэн техникээр хадаж байвал гэрээг цуцалж хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

4.11. Хадлангийн талбайг сорчилж хадахгүй.

4.12. Хадлангийн талбайг өмнө нь эзэмшиж байсан иргэнд эхлэж хувиарлах бөгөөд 2 жил өөр иргэнд хадуулсан тохиолдолд давуу эрх олгож гэрээ байгуулахгүй болно.

ТАВ: БАЙГАЛИЙН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР АВАХ

5.1 Иргэн автомашинд задгай өвс хадаж, ачиж тээвэрлэсэн тохиолдолд

5.1.1. 5 тонноос доош автомашинд -50,000 мянган төгрөг,

5.1.2. 5 тонноос дээш автомашинд -100,000 мянган төгрөг

5.2. Иргэн өвс хадаж боодол болгосон тохиолдолд нэг боодлыг 150-200 төгрөгөөр тооцно.

ЗУРГАА: ИРГЭНД НООГДОХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

6.1 Том трактортай өрхөд 25 га хүртэлх

6.2 Жижиг трактортай өрхөд 15 га хүртэлх

6.3 Гар хадууртай иргэнд 2 га хүртэлх талбайг гэрээний дагуу иргэнд байгаль хамгаалагч хадлангийн талбайг зааж өгч координат тогтоож ажлыг эхлүүлнэ.